



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/01

Мандалговь

2019 оныг “Бүтээн байгуулалт, Иргэн төвтэй”
төрийн үйлчилгээ”-ний жил болгох тухай

Улсын Их хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилт, Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг чанаржуулах зорилгоор 2019 оныг “Бүтээн байгуулалт, Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жил болгон зарласугай.

Хоёр. “Бүтээн байгуулалт, Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жилийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Гурав. Жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллан тайланг 2019 оны 6, 12 дугаар сарын 5-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

Дөрөв. “Бүтээн байгуулалт, Иргэн төвтэй төрийн үйлчилгээ”-ний жилийн ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн)-т, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т, ажлын явц, үр дүнг хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, дотоод аудит хийж аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Г.Самданцоодол)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010002



Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын
04-ний өдрийн 04 тоот захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Гишүүд:
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
 - Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
 - Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
 - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
 - Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
 - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн
 - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
 - Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
 - Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн
 - Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Эдийн засгийн бодлого төлөвлөлт хариуцсан ерөнхий эдийн засагч
 - Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн
 - Мэргэжлийн хяналтын газрын дарга
 - Боловсрол, соёл урлагийн газрын дарга
 - Эрүүл мэндийн газрын дарга
 - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
 - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
 - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
 - Сайнцагаан сумын Засаг дарга
 - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга